

難民等認定手続案内
Дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх
журмын гарын авлага

【第 6 版】
(6 дахь хэвлэл)

2024 年 12 月
2024 он 12 сар
出入国在留管理庁
Х илийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын
газар

はじめに Оршил

難民認定手続案内（第 1 版）は、我が国の難民の地位に関する条約等への加入に伴い、難民認定手続を整備するため、1981 年に一部改正された出入国管理及び難民認定法を基に編集したものです。

Дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх журмын тухай гарын авлага (1-р хэвлэл) нь Япон улс дүрвэгсдийн статусын тухай конвенцид нэгдэн орсны дараа дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх журмыг боловсронгуй болгох үүднээс 1981 онд хэсэгчлэн шинэчилэгдсэн Гадаад иргэн, дүрвэгчийн зөвшөөрлийн тухай хуульд үндэслэн эмхэтгэсэн гарсан билээ.

その後、2004 年 6 月 2 日に公布された、仮滞在許可制度及び難民審査参与員制度の創設を内容とする「出入国管理及び難民認定法の一部を改正する法律」の内容を基に、加筆・修正を加えて第 2 版を発行、一時庇護手続について記載した第 3 版を発行、2009 年 7 月 15 日に公布された、新たな在留管理制度の導入を内容とする「出入国管理及び難民認定法の一部を改正する法律」の内容を基に加筆・修正を加えた第 4 版を発行、2016 年 4 月 1 日に施行された、不服申立ての手続を審査請求に一元化することなどを内容とする行政不服審査法の全部改正を受けて第 5 版を発行してまいりました。

Түүний дараагаар 2004 оны 6-р сарын 2-ны өдөр, түр оршин суух зөвшөөрлийн тогтолцоо болон дүрвэгсдийн хяналт шалгалтын комиссын тогтолцоо бүхий агуулгатай "Гадаад иргэн, дүрвэгчийн зөвшөөрлийн тухай хуульд хэсэгчлэн өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн агуулгад үндэслэн нэмэлт, засвар бүхий хоёр дахь хэвлэл нийтлэгдсэн. 2009 оны 7-р сарын 15-ны өдөр түр орогнох журмыг тодорхойлсон гурав дахь хэвлэл нийтлэгдсэн. Түүнчлэн оршин суух зөвшөөрлийн хяналтын шинэ тогтолцоог нэвтрүүлсэн "Гадаад иргэн, дүрвэгчийн зөвшөөрлийн тухай хуульд хэсэгчлэн өөрчлөлт оруулах тухай хууль"-ийн агуулгад үндэслэн нэмэлт, өөрчлөлт бүхий дөрөв дэх хэвлэлийг баталж 2016 оны 4-р сарын 1-ний өдрөөс хэрэгжиж эхэлсэн. Мөн давж заалдах журмуудыг нэгтгэн хянуулах хүсэлт гаргах зэрэгт чиглэсэн захиргааны хэргийн давж заалдах тухай хуулийн бүрэн шинэчилэн найруулагдсан тав дахь хэвлэл нийтлэгдсэн.

今般、2018 年 12 月 14 日に公布された、出入国在留管理庁の設置等を内容とする、「出入国管理及び難民認定法及び法務省設置法の一部を改正する法律」及び 2023 年 6 月 16 日に公布された、補完的保護対象者認定制度の創設等を内容とする、「出入国管理及び難民認定法及び日本国との平和条約に基づき日本の国籍を離脱した者等の出入国管理に関する特例法の一部を改正する法律」の内容を基に加筆・修正を加えた第 6 版を発行するものです。

Энэ удаад 2018 оны 12-р сарын 14-ний өдөр нийтлэгдсэн Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар байгуулах тухай агуулга бүхий "Гадаад иргэн, дүрвэгчийн зөвшөөрлийн тухай хууль болон Хууль зүйн яамыг байгуулах тухай хуульд хэсэгчлэн өөрчлөлт оруулах тухай хууль", түүнчлэн 2023 оны 6-р сарын 16-нд нийтлэгдсэн тусгай хамгаалалтыг зөвшөөрөх тогтолцоог бий болгох агуулга бүхий "Гадаад иргэн, дүрвэгчийн зөвшөөрлийн тухай хууль болон Япон улстай байгуулсан энх тайвны гэрээний дагуу Япон улсын иргэншлээ алдсан иргэдийн цагаачлалын хяналтын тухай тусгай хуулийг хэсэгчлэн шинэчилэх тухай хууль"-ийн агуулгад үндэслэн шинэчлэн найруулж, өргөтгөсөн 6 дахь хэвлэлийг нийтэлж байна.

2024 年 12 月
2024 он 12 сар

出入国在留管理庁
Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар

目次

Гарчиг

第 1	日本の難民認定制度及び補完的保護対象者認定制度の概要	1
1-р хэсэг:	Японы дүрвэгчийн зөвшөөрөл болон тусгай хамгаалалтын зөвшөөрлийн тогтолцооны товч агуулга	1
第 2	難民の認定又は補完的保護対象者の認定を受けた外国人が 享受できる利益	3
2-р хэсэг	Дүрвэгсдийн зөвшөөрөл эсвэл тусгай хамгаалалтад хамрагдах зөвшөөрөл авсан гадаад иргэдэд олгогдох боломж.....	3
1	永住許可要件の一部緩和	3
1	Байнгын оршин суух зөвшөөрөлд тавигдах шаардлагаас хэсэгчлэн хөнгөвчлөгдөх	3
2	難民旅行証明書の交付（難民の認定を受けた外国人に限ります。）	3
2	Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ олгох (зөвхөн дүрвэгчийн зөвшөөрөл авсан гадаадын иргэдэд).....	3
第 3	難民等認定手続.....	4
3-р хэсэг:	Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх журам	4
1	申請手続	4
1	Өргөдөл гаргах журам.....	4
(1)	申請期間.....	4
(1)	Өргөдөл гаргах хугацаа	4
(2)	申請窓口	4
(2)	Өргөдөл хүлээж авах цонх.....	4
(3)	申請に必要な書類.....	4
(3)	Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд.....	4
(4)	難民又は補完的保護対象者であることの立証.....	7
(4)	Дүрвэгч эсвэл тусгай хамгаалалт авах шаардлагатай хүн гэдгийг батлах баримт	7
2	仮滞在の許可	7
2	Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл	7
(1)	仮滞在許可による滞在.....	8
(1)	Түр оршин суух зөвшөөрлийн дагуу оршин суух	8
(2)	仮滞在許可書.....	8
(2)	Түр оршин суух зөвшөөрөл.....	8
(3)	仮滞在期間及び同期間の延長	8
(3)	Түр оршин суух хугацаа болон хугацаа сунгах	8
(4)	仮滞在許可の条件.....	9
(4)	Түр оршин суух нөхцөл	9
(5)	報酬を受ける活動の許可	9

(5) Цалинтай ажил хийх зөвшөөрөл.....	9
(6) 仮滞在の許可の取消し.....	11
(6) Түр оршин суух зөвшөөрлийг цуцлах.....	11
3 難民認定証明書等の交付.....	11
3 Дүрвэгчийн зөвшөөрөл олгох.....	11
4 在留資格に係る許可.....	11
4 Оршин суух статусын зөвшөөрөл.....	11
第4 審査請求.....	12
4-р хэсэг: Шалгуулах хүсэлт гаргах.....	12
1 審査請求手続.....	12
1 Шалгуулах хүсэлт гаргах журам.....	12
(1) 審査請求人.....	12
(1) Шалгуулах хүсэлт гаргагч.....	12
(2) 審査請求ができる期間.....	12
(2) Шалгуулах хүсэлт гаргаж болох хугацаа.....	12
(3) 審査請求の窓口.....	12
(3) Шалгуулах хүсэлтийг хүлээж авах цонх.....	12
(4) 審査請求に必要な書類.....	13
(4) Шалгуулах хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримтууд.....	13
2 難民審査参与員.....	13
2 Дүрвэгсдийг хянан шалгах комиссын гишүүн.....	13
3 法務大臣の裁決.....	13
3 Хууль зүйн сайдын тогтоол.....	13
第5 難民旅行証明書.....	15
5-р хэсэг Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ.....	15
1 申請窓口.....	15
1 Өргөдөл өгөх цонх.....	15
2 申請に必要な書類.....	15
2 Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд.....	15
(1) 提出書類.....	15
(1) Бүрдүүлэх бичиг баримтууд.....	15
(2) 提示書類.....	16
(2) Бүрдүүлэх бичиг баримт.....	16
3 難民旅行証明書の有効期間.....	16
3 Дүрвэгсдийн аялалын гэрчилгээний хүчинтэй хугацаа.....	16
4 手数料.....	17
4 Хураамж.....	17

第 6 一時庇護のための上陸許可	18
6-р хэсэг Түр оргонох зорилгоор хил нэвтрэх зөвшөөрөл олгох	18
1 申請	18
1 Өргөдөл гаргах.....	18
(1) 対象者.....	18
(1) Зорилтот иргэн.....	18
(2) 申請方法.....	18
(2) Өргөдөл гаргах арга	18
2 申請に必要な書類	18
2 Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд	18
(1) 提出書類.....	18
(1) Бүрдүүлэх бичиг баримтууд	18
(2) 提示書類.....	19
(2) Шалгуулах бичиг баримт.....	19
3 一時庇護許可書の交付	19
3 Түр орогнох зөвшөөрөл олгох	19
付録 難民認定手続・補完的保護対象者認定手続図解.....	20
Хавсралт: Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх, тусгай хамгаалалтад хамрагдах журмын бүдүүвч зураг	20

第1 日本の難民認定制度及び補完的保護対象者認定制度の概要

1-р хэсэг: Японы дүрвэгчийн зөвшөөрөл болон тусгай хамгаалалтын зөвшөөрлийн тогтолцооны товч агуулга

難民の地位に関する条約（以下「難民条約」という。）及び難民の地位に関する議定書（以下「議定書」という。）が1982年に我が国について発効したことに伴い、難民条約及び議定書の諸規定を国内で実施するため、難民認定制度が整備されました。この制度では、難民である外国人は、難民認定申請を行い、法務大臣から難民であるとの認定を受けることができ、また、難民条約に規定する難民としての保護を受けることができます。

Дүрвэгсдийн статусын тухай конвенц (цаашид "дүрвэгсдийн конвенц" гэх) болон дүрвэгсдийн статусын тухай протокол (цаашид "протокол" гэх) нь 1982 онд Япон улсад хүчин төгөлдөр болсноос хойш дүрвэгсдийн тухай конвенц болон түүний протоколын заалтуудыг дотооддоо хэрэгжүүлэх зорилгоор дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх тогтолцоог бий болгосон. Энэхүү тогтолцооны дагуу гадаадын дүрвэгч иргэд дүрвэгчийн статус авах хүсэлт гаргаж, Хууль зүйн сайдаас дүрвэгчийн зөвшөөрөл авах боломжтой болсон бөгөөд, Дүрвэгсдийн конвенцид заасны дагуу дүрвэгчийн хамгаалалтад хамрагдах боломжтой.

本案内でいう「難民」とは、難民条約第1条又は議定書第1条の規定により定義される難民を意味し、それは、人種、宗教、国籍、特定の社会的集団の構成員であること又は政治的意見を理由として迫害を受けるおそれがあるという十分に理由のある恐怖を有するために国籍国の外にいる者であって、その国籍国の保護を受けることができないか又はそれを望まない者とされています。

Энэхүү гарын авлагад гарч буй "Дүрвэгч" гэсэн нэр томъёо нь 1951 оны Конвенцийн 1 дүгээр зүйл болон Протоколын 1 дүгээр зүйлд тодорхойлсон дүрвэгчийг хэлэх бөгөөд уг дүрвэгсдийг арьсны өнгө, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн тодорхой бүлгийн гишүүнчлэл, улс төрийн үзэл бодлын улмаас хавчлагад өртөх эрсдэл бүхий үндэслэл, айдасаасаа болж тухайн улсын харьяалалаасаа гадуур байх этгээд бөгөөд тухайн улсынхаа хамгаалтад байх боломжгүй эсвэл хүсэхгүй байгаа иргэнийг хэлнэ.

難民認定手続とは、外国人がこの難民の地位に該当するかどうかを審査し決定する手続です。

Дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх журам гэдэг нь тухайн гадаадын иргэн дүрвэгчийн статус авах болзол хангасан эсэхийг шалгаж, тодорхойлох үйл явц юм.

一方で、近年、紛争避難民のように、難民条約上の難民には該当しないものの、難民と同様に保護を必要とする外国人が増加していることを受け、2023年12月1日、補完的保護対象者認定制度が開始されました。この制度では、本邦にある外国人は、難民認定申請又は補完的保護対象者認定申請を行い、法務大臣から補完的保護対象者であるとの認定を受けることができます（難民認定申請をした外国人について、難民の認定をしない処分がされる場合に、当該外国人が補完的保護対象者に該当すると認められるときは、補完的保護対象者として認定されます。）。

Нөгөө талаас, сүүлийн жилүүдэд дайны дүрвэгсдийн адилаар Дүрвэгсдийн конвенцид заасны дагуу дүрвэгсдийн шалгуурыг хангахгүй ч бусад дүрвэгсэдтэй адил хамгаалалт авах шаардлагатай гадаадын иргэдийн тоо нэмэгдэж байгаатай холбогдуулан 2023 оны 12-р сарын 1-ний өдрөөс эхлэн тусгай хамгаалалтын зөвшөөрөл олгох тогтолцоог хэрэгжүүлж эхэлсэн. Энэхүү тогтолцооны дагуу Японд байгаа гадаадын иргэд дүрвэгчийн статус эсвэл тусгай хамгаалалтын зөвшөөрөл авах хүсэлт гаргаж, Хууль зүйн сайдаас тусгай хамгаалалтын зөвшөөрөл авах боломжтой (хэрэв дүрвэгчийн статус хүссэн гадаадын

иргэнийг дүрвэгч гэж хүлээн зөвшөөрөөгүй ч тусгай хамгаалалт шаардлагатай гэж үзвэл түүний тусгай хамгаалалтыг хүлээн зөвшөөрөх болно).

本案内でいう「補完的保護対象者」とは、難民条約上の難民以外の者であって、難民条約上の要件のうち、「迫害を受けるおそれがある理由が、人種、宗教、国籍、特定の社会的集団の構成員であること又は政治的意見であること」以外の要件を満たす者とされています。

Энэхүү гарын авлагад гарч буй "Тусгай хамгаалалт авах хүн" гэдэг нь Дүрвэгсдийн тухай конвенцид заасан дүрвэгчээс бусад дүрвэгсдийг хэлж байгаа бөгөөд уг конвенцид заасан "арьс угсаа, шашин шүтлэг, үндэс угсаа, нийгмийн тодорхой бүлгийн гишүүнчлэл, улс төрийн үзэл бодлын улмаас хавчигдах айдас"-аас бусад болзолыг хангасан хүнийг хэлнэ.

なお、本案内において、難民と補完的保護対象者を合わせて「難民等」といい、難民認定手続と補完的保護対象者認定手続を合わせて「難民等認定手続」といいます。

Энэхүү гарын авлагад дүрвэгсэд болон тусгай хамгаалалтад хамрагдах хүмүүсийг хамтад нь "Дүрвэгсэд гм" гэх бөгөөд, дүрвэгсдийн зөвшөөрөл болон тусгай хамгаалалтын зөвшөөрөл мэдүүлэх журмыг нийтэд нь "Дүрвэгсдийг хүлээн зөвшөөрөх журам" гэж нэрлэнэ.

第2 難民の認定又は補完的保護対象者の認定を受けた外国人が 享受できる利益

2-р хэсэг Дүрвэгсдийн зөвшөөрөл эсвэл тусгай хамгаалалтад хамрагдах зөвшөөрөл авсан гадаад иргэдэд олгогдох боломж

難民の認定又は補完的保護対象者の認定を受けた外国人は、次のような利益を受けることができます。

Дүрвэгсдийн зөвшөөрөл эсвэл тусгай хамгаалалтад хамрагдах зөвшөөрөл авсан гадаад иргэд дараах боломжуудыг ашиглах боломжтой.

1 永住許可要件の一部緩和

1 Байнгын оршин суух зөвшөөрөлд тавигдах шаардлагаас хэсэгчлэн хөнгөвчлөгдөх

日本に在留する外国人が永住許可を受けるためには、
Японд оршин суугаа гадаадын иргэн байнгын оршин суух зөвшөөрөл авахын тулд、

① 素行が善良であること

Сахилга баттай байх

② 独立の生計を営むに足る資産又は技能を有すること

Бие даан амьдрах эдийн засгийн боломж, ур чадвар эзэмшсэн байх

の2つの要件を満たし、かつ、その者の永住が日本国の利益に合すると認められなければならないとされています。

Дээрх хоёр шаардлагыг хангасан байх ёстой бөгөөд тухайн хүн байнга оршин суух газар нь Япон улсын ашиг сонирхолд нийцэж байх ёстой гэсэн байдаг.

しかし、難民の認定又は補完的保護対象者の認定を受けて在留する外国人は、このうち②の要件を満たさない場合であっても、法務大臣の裁量により永住許可を受けることができます。

Гэсэн хэдий ч, дүрвэгсдийн болон тусгай хамгаалалтын зөвшөөрөл авсан гадаад иргэн ②-д заасан шаардлагыг хангаагүй байсан ч Хууль зүйн сайдын тогтоолоор байнгын оршин суух эрх олгож болно.

2 難民旅行証明書の交付（難民の認定を受けた外国人に限ります。）

2 Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ олгох (зөвхөн дүрвэгчийн зөвшөөрөл авсан гадаадын иргэдэд)

難民の認定を受けた外国人が外国に旅行しようとするときは、難民旅行証明書の交付を受けることができます。難民旅行証明書を所持する外国人は、その証明書に記載されている有効期間内であれば、原則として何度でも日本から出国し、日本に再入国することができます（申請手続等については、本案内第5を参照。）。

Дүрвэгчийн зөвшөөрөл авсан гадаад иргэн гадаадад зорчих хүсэлтэй байгаа тохиолдолд түүнд дүрвэгчийн аялалын гэрчилгээ олгож болно. Зарчмын хувьд дүрвэгсдийн аялалын гэрчилгээтэй гадаадын иргэн тухайн баримт бичигт заасан хүчинтэй хугацаанд хэдэн ч удаа Японоос гарч, дахин орж болно (өргөдөл мэдүүлэх журам гэх мэтийг энэ гарын авлагын 5-р хэсгээс үзнэ үү).

なお、補完的保護対象者の認定を受けた外国人が外国に旅行しようとするときは、難民旅行証明書の交付は受けられないものの、再入国許可書の交付を受けることができます。

Харин тусгай хамгаалалтын зөвшөөрөл авсан гадаадын иргэн гадаадад зорчихыг хүсвэл дүрвэгсдийн аялалын гэрчилгээ олгохгүй бөгөөд хэдий ч дахин нэвтрэх зөвшөөрөл олгоно.

第3 難民等認定手続

3-р хэсэг: Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх журам

1 申請手続

1 Өргөдөл гаргах журам

(1) 申請期間

(1) Өргөдөл гаргах хугацаа

難民等認定申請の期間について制限する規定はありません。

Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх өргөдөл гаргах хугацааг хязгаарласан зохицуулалт байхгүй.

(2) 申請窓口

(2) Өргөдөл хүлээж авах цонх

難民等認定申請は、申請者の住居地（住居地がないときは宿泊先等の所在地。以下「住居地等」といいます。）を管轄する地方出入国在留管理局、支局及び出張所で行うことができます。

Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх өргөдлөө өргөдөл гаргагчийн оршин суугаа газар (оршин суух хаяггүй бол байрлаж буй газар; цаашид "оршин суугаа газар" гэх) -ын харьяалал бүхий орон нутгийн Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын салбар болон төлөөллийн газарт өгч болно.

申請は、申請者本人が自ら出頭して行ってください。ただし、申請者が16歳未満である場合や病気その他の理由により自ら出頭できない場合は、父母、配偶者、子又は親族がその者に代わって申請を行うことができます。

Өргөдлийг өргөдөл гаргагч өөрийн биеэр мэдүүлэх ёстой. Харин өргөдөл гаргагч нь 16 нас хүрээгүй буюу өвчний болон бусад шалтгаанаар өөрийн биеэр ирж чадахгүй бол эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд болон бусад хамаатан садан нь түүний өмнөөс хүсэлт гаргаж болно.

地方出入国在留管理局・支局における窓口については、本案内の最終ページを参照してください。

Бүс нутгийн Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар, салбаруудын мэдээлэл өгөх цонхны талаарх мэдээллийг энэхүү гарын авлагын сүүлийн хуудаснаас харна уу.

(3) 申請に必要な書類

(3) Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд

申請には、次の書類が必要です。なお、怪我や身体の障害などの特段の事情があるため難民・補完的保護対象者認定申請書の記載ができない外国人は、申請書に代えて申請書に記載すべき事項を入国審査官又は難民調査官に陳述してもよいことになっています。

Өргөдөл гаргахад дараах бичиг баримтыг бүрдүүлэх шаардлагатай. Гэхдээ гэмтэл бэртэл авсан, хөгжлийн бэрхшээлтэй зэрэг онцгой нөхцөл байдлын улмаас дүрвэгсдийн болон тусгай хамгаалалтын зөвшөөрөл авах хүсэлтээ бөглөх боломжгүй гадаадын иргэн өргөдлийн маягтанд бичигдэх агуулгыг гаалийн байцаагч болон, дүрвэгсдийн байцаагчид хэлж бичүүлж болно.

① 提出書類

Бүрдүүлэх бичиг баримтууд

- ア 難民・補完的保護対象者認定申請書（入管庁のホームページに掲載されているほか、窓口でも配布しています。） 1 通
- Дүрвэгч / тусгай хамгаалалтын зөвшөөрөл хүсэх өргөдөл（Энэ маягтыг Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын вэб сайтаас авах боломжтой бөгөөд мөн биеэр очиж авах боломжтой.） 1 хувь
- ※過去に難民等の認定をしない処分を受けたことがある外国人は再申請用の申請書を提出する必要がありますので、御留意ください。
- *Өмнө нь дүрвэгчийн зөвшөөрөл олгохоос татгалзах хариу авч байсан гадаадын иргэн дахин мэдүүлэх өргөдлийн маягт бүрдүүлэх шаардлагатайг анхаарна уу.
- イ 申請者が難民又は補完的保護対象者であることを証明する資料（難民又は補完的保護対象者であることを主張する陳述書を含む。） 1 通
- Өргөдөл гаргагч нь дүрвэгч эсвэл тусгай хамгаалалтын зөвшөөрөл хүсэх эрхтэй хүн гэдгийг нотлох баримт（дүрвэгч эсвэл тусгай хамгаалалтын зөвшөөрөл хүсэх эрхтэй хүн гэдгийг тодорхой бичсэн өргөдөл хамаарна.） 1 хувь
- ウ 写真（以下の要件を満たし、裏面に氏名が記載されているもの。） 1 葉
- Цээж зураг（доорх шаардлагыг хангасан байх шаардлагатай бөгөөд ард талд нь нэрээ бичсэн байх） 1 хувь
- （ただし、在留資格未取得外国人については、2 葉）
- （Гэхдээ, оршин суух зөвшөөрөл аваагүй гадаад иргэдийн хувьд, 2 хувь）

【要件】


【Тавигдах шаардлага】

- （ア） 申請者本人のみが撮影されたものであること
- Зөвхөн өргөдөл гаргагчийн зураг байх

- （イ） 写真の寸法
- Цээж зургийн хэмжээ

縁を除いた部分の寸法が、下記の寸法を満たしたものであること（顔の寸法は、頭頂部（髪を含む。）からあご先まで）

Ирмэгээс бусад хэсгийн хэмжээсүүд нь доорх хэмжээтэй тохирч байх ёстой（нүүрний хэмжээс нь зулхайгаас（үс оруулаад）эрүүний үзүүр хүртэл）



- (ウ) 無帽で正面を向いたものであること(宗教上又は医療上の理由により本要件を満たす写真を提出することができない特段の事情がある場合、当該事情に係る陳述書(任意様式)を提出してください。)

Малгайгүй, цэх урагш харсан байх ёстой. (Хэрэв танд шашны болон эрүүл мэндийн шалтгааны улмаас эдгээр шаардлагыг хангасан гэрэл зураг өгөхөд хүндрэлтэй, онцгой нөхцөл байдал байгаа бол тухайн нөхцөл байдлаа тайлбарласан мэдэгдэл (маягтын чөлөөт хэлбэрээр)-г хавсаргана уу.)

- (エ) 背景(影を含む。)がないものであること

Арын дэвсгэр(сүүдэр) байх ёсгүй.

- (オ) 鮮明であること(写真の焦点が合っているもの、しみ、汚れ、穴等がなく、顔写真に影がないもの、衣服や頭髮等により目、鼻、口等が隠れていないもの、背景がないもの等。出入国在留管理庁ホームページに掲載している申請用写真の見本・事例集を参照してください。)

Тод гарсан зураг байх. (фокус тохирсон, толбогүй, бохирдолгүй, цоороогүй, нүүр хэсэгт сүүдэр тусаагүй, нүд, хамар, ам зэрэг хэсгүүд хувцас болон үсэнд халхлагдаагүй, арын дэвсгэр байхгүй гэх мэт). Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газрын вэб сайтад байршуулсан өргөдлийн зургийн жишээ болон жишээнүүдийг үзнэ үү.)

- (カ) 提出の日前 6 か月以内に撮影されたものであること(入院中のため写真を撮影することができないなど、6 か月以内に撮影した写真を提出できないことについてやむを得ない理由がある場合には、可能な限り新しい写真を提出してください。)

Зургийг өргөдөл өгөхөөс зургаан сарын дотор авсан байх. (Эмнэлэгт хэвтсэний улмаас зургаа авахуулах боломжгүй гэх мэт зайлшгүй шалтгаанаар сүүлийн зургаан сарын дотор авхуулсан зураг байхгүй бол, аль болох шинэ зураг өгнө үү.)

- エ 旅券又は在留資格証明書を提示できない者にあつては、その理由を記載した書類 1 通
Гадаад паспорт болон оршин суух эрхийн бичиг баримтгүй бол, уг шалтгааныг илтгэх
баримт бичиг хавсаргах. 1 хувь

② 提示書類

Шалгуулах бичиг баримт

- ア 中長期在留者にあつては、旅券及び在留カード

Дунд болон урт хугацаагаар оршин суугчдын хувьд гадаад паспорт, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх

- イ 特別永住者にあつては、旅券及び特別永住者証明書

Тусгай байнгын оршин суугчдын хувьд гадаад паспорт, тусгай байнгын оршин суугчийн тодорхойлолт

- ウ 中長期在留者及び特別永住者以外の者にあつては、旅券又は在留資格証明書

Дунд болон удаан хугацаагаар оршин суугчид болон тусгай байнгын оршин суугчдаас бусад хүмүүсийн хувьд гадаад паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн үнэмлэх
(監理措置中の者にあつては、監理措置決定通知書)

(Хяналтанд байгаа хүмүүсийн хувьд, хяналтын шийдвэрийн тухай мэдэгдэл)
(仮放免中の者にあつては、仮放免許可書)
(Түр чөлөөлөгдсөн хүмүүсийн хувьд түр чөлөөлөх гэрчилгээ)

エ 仮上陸の許可、船舶観光上陸の許可、乗員上陸の許可、緊急上陸の許可、遭難による上陸の許可又は一時庇護のための上陸の許可を受けている者にあつては、当該許可書
Түр газардах зөвшөөрөл, хөлөг онгоцны жуулчлалын зөвшөөрөл, зорчигчид газардах зөвшөөрөл, ослын буулт хийх зөвшөөрөл, гамшигаас үүдэх ослын буулт хийх зөвшөөрөл эсвэл түр оргонох зөвшөөрөлтэй бол холбогдох зөвшөөрлийн бичиг

(4) 難民又は補完的保護対象者であることの立証

(4) Дүрвэгч эсвэл тусгай хамгаалалт авах шаардлагатай хүн гэдгийг батлах баримт

難民等の認定は、申請者から提出された資料や申請者の供述等に基づいて行われます。したがって、申請者は、難民等であることについて自ら立証することが求められます。なお、資料（陳述書を含む。）が外国語で作成されているときは、その資料の訳文を添付してください。

Дүрвэгчийн зөвшөөрөл нь, өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичиг болон мэдэгдэл зэрэгт үндэслэн шийдэгддэг. Иймд өргөдөл гаргагч нь дүрвэгчийн статустай болох эсэхээ өөрөө нотлох шаардлагатай. Хэрвээ баримт бичиг (мэдүүлэг орно) нь гадаад хэл дээр бичигдсэн бол япон хэл дээрх орчуулгыг хавсаргана уу.

申請者の提出した資料のみでは十分な立証が得られない場合には、難民調査官が公務所等に照会するなどして、申請者の申し立てる事実の有無について調査し、難民等の認定が適正に行われるように努めます。

Өргөдөл гаргагчийн ирүүлсэн баримт бичиг нь нотолгооны хувьд хангалтгүй байх тохиолдолд, өргөдөл гаргагчийн мэдүүлсэн баримт үнэн эсэхийг шалгахын тулд дүрвэгсдийн мөрдөн байцаагч төрийн албан байгууллагад асуулга хийж, дүрвэгчийн зөвшөөрлийг зохих ёсоор шийдвэрлэхэд хичээн зүтгэх болно.

2 仮滞在の許可

2 Түр хугацаагаар оршин суух зөвшөөрөл

不法滞在者等の在留資格未取得外国人から難民等認定申請があったときは、その者の法的地位の安定を図るため、当該外国人が本邦に上陸した日（本邦にある間に難民等となる事由が生じた者にあつては、その事実を知った日）から 6 か月以内に難民等認定申請を行ったものであること、迫害を受けるおそれのあった領域から直接本邦に入ったものであることなどの一定の要件を満たす場合には、仮に本邦に滞在することを許可し、その間は退去強制手続が停止されます。

Хууль бусаар оршин суугч болон оршин суугчийн зөвшөөрөлгүй гадаадын иргэн дүрвэгчийн зөвшөөрөл хүссэн тохиолдолд тухайн хүний эрх зүйн байдлыг хангах үүднээс, гадаадын иргэн Япон улсад хөл тавьсан өдөр (эсвэл Японд байх хугацаандаа дүрвэгч болсон иргэний хувьд уг баримтыг мэдсэн өдөр)-өөс хойш 6 сарын дотор өргөдөл гаргасан байх, мөн тухайн гадаадын иргэн аюул эрсдэлд орох магадлалтайн улмаас Япон улсын нутаг дэвсгэрт шууд орж ирсэн зэрэг тодорхой шаардлагыг хангасан тохиолдолд Японд оршин суухыг түр хугацаагаар зөвшөөрөх бөгөөд энэ хугацаанд албадан гаргах журмыг түдгэлзүүлнэ.

なお、仮滞在許可の判断は、難民等認定申請者から提出のあった難民・補完的保護対象者認定申請書等の書類により行いますので、別途、仮滞在許可のための申請は必要ありません。

Түр оршин суух зөвшөөрөл олгох шийдвэрийг дүрвэгч болон тусгай хамгаалалтын зөвшөөрөл мэдүүлэгчийн мэдүүлсэн баримт бичгүүдэд үндэслэн гаргах бөгөөд тусад нь түр оршин суух зөвшөөрөл авах өргөдөл гаргах шаардлагагүй.

(1) 仮滞在許可による滞在

(1) Түр оршин суух зөвшөөрлийн дагуу оршин суух

仮滞在許可を受けると一時的に退去強制手続が停止され、仮滞在期間の経過等により当該許可が終了するまでの間は、適法に本邦に滞在することができます。

Түр оршин суух зөвшөөрөл авсан тохиолдолд албадан гаргах ажиллагааг түр зогсоох бөгөөд түр оршин суух хугацаа дуусах хүртэлх хугацаанд хууль ёсны дагуу оршин суух боломжтой.

(2) 仮滞在許可書

(2) Түр оршин суух зөвшөөрөл

法務大臣が仮滞在の許可をした外国人には、仮滞在許可書が交付されます。

Хууль зүйн сайдын тушаалаар түр оршин суух зөвшөөрөл авсан гадаадын иргэдэд түр оршин суух зөвшөөрөл олгоно.

許可を受けている間は、この許可書を常に携帯する必要があります。

Зөвшөөрөл авсан хугацаандаа энэ зөвшөөрлийн бичиг баримтыг биедээ авч явах ёстой.

(3) 仮滞在期間及び同期間の延長

(3) Түр оршин суух хугацаа болон хугацаа сунгах

仮滞在期間は、原則として6月です。

Түр оршин суух хугацаа нь зарчмын хувьд зургаан сар байна.

仮滞在期間の更新申請は、許可期限の10日前から、申請者の住居地等を管轄する地方出入国在留管理局、支局及び出張所で受け付けています。また、申請書は、入管庁のホームページに掲載されているほか、各地方出入国在留管理局、支局及び出張所の窓口で配布しています。

Түр оршин суух хугацаа сунгах өргөдлийг хугацаа дуусахаас 10 хоногийн өмнө өргөдөл гаргагчийн оршин суугаа газрын харьяаллын хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар болон салбар хэлтсүүдээр хүлээн авна. Түүнчлэн өргөдлийн маягтыг хилийн шалган нэвтрүүлэх газрын веб сайтаас авах боломжтой бөгөөд мөн тухайн бүс нутгийн хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар болон салбар хэлтсүүдээс авах боломжтой.

地方出入国在留管理局・支局における窓口については、本案内の最終ページを参照してください。

Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар болон салбар хэлтсүүдийн талаарх мэдээллийг энэхүү гарын авлагын сүүлийн хуудаснаас авна уу.

- (4) 仮滞在許可の条件
(4) Түр оршин суух нөхцөл

仮滞在許可を受けた者は、住居や行動範囲が制限されるほか、難民調査官から出頭の要請があった場合には、指定された日時、場所に出頭して、難民等認定手続へ協力する義務が課されるなど、種々の条件が付されます。

Түр оршин суух зөвшөөрөл авсан хүнд амьдрах газар болон явж болох орчны хязгаарлалт хийх бөгөөд, дүрвэгсдийн байцаагчийн заасан өдөр, цаг, газарт ирж дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх бичиг баримт бүрдүүлтэд хүчин чармайлалт гаргах хэрэгтэй зэрэг болзол тавигддаг.

- (5) 報酬を受ける活動の許可
(5) Цалинтай ажил хийх зөвшөөрөл

仮滞在の許可を受けた者が生計を維持するために必要な範囲で行う報酬を受ける活動について、相当と認められるときには許可される場合があります。

Түр оршин суух зөвшөөрөл авсан хүмүүс амьжиргаагаа хангахад шаардлагатай гэж үзвэл цалинтай үйл ажиллагаа эрхлэхийг зөвшөөрч болно.

① 申請期間

Өргөдөл гаргах хугацаа

仮滞在許可を受けた日から当該許可の満了日までの間

Түр оршин суух зөвшөөрлийг хүлээн авсан өдрөөс эхлэн зөвшөөрлийн хугацаа дуусах хүртэл

② 申請窓口

Өргөдөл хүлээж авах цонх

申請者の住居地等を管轄する地方出入国在留管理局、支局及び出張所で行うことができます。

Өргөдөл гаргагчийн оршин суугаа орон нутгийн Хилийн шалган нэвтрүүлэх газар болон салбар хэлтсүүдэд хүргэж болно.

③ 申請に必要な書類

Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд

ア 報酬を受ける活動許可申請書（入管庁のホームページに掲載されているほか、窓口でも配布しています。） 1 通

Цалинтай ажил хийх зөвшөөрөл авах өргөдөл (Хилийн шалган нэвтрүүлэх газрын вэб хуудаснаас авах болон биеэр ирж авч болно) 1 хувь

イ 労働基準法第 15 条第 1 項及び同法施行規則第 5 条に基づき、労働者に交付される労働条件を明示する文書

Хөдөлмөрийн стандартын тухай хуулийн 15 дугаар зүйлийн 1 дэх хэсэг болон мөн хуулийн хэрэгжилтийн журмын 5 дугаар зүйлийг үндэслэсэн ажилчдад олгох хөдөлмөрийн нөхцөлийг тодорхой заасан баримт бичиг

- ウ 就業予定機関について、本邦内に本店又は事業所等があることを疎明する資料（パンフレット、登記事項証明書など）
Ажиллах гэж буй байгууллагын төв оффис эсвэл үйл ажиллагааны оффистой болохыг нотлох баримт бичиг (компанийн танилцуулга, компанийн бүртгэлийн гэрчилгээ гэх мэт)
 - エ 就業予定機関の直近3ヶ月分の給与所得・退職所得等の所得税徴収高計算書の写し
Ажиллахаар төлөвлөж буй байгууллагын сүүлийн гурван сарын цалингийн орлого, ажлаас гарах олговор гэх мэт орлогын албан татварын тайлангийн хуулбар
 - オ 申請者の収入又は資産を疎明する資料
Өргөдөл гаргагчийн орлого, хөрөнгийг баталгаажуулсан баримт бичиг
 - カ 同居者等の収入又は資産を疎明する資料（申請者と生計を一にする同居者等がいる場合）
Хамтран амьдардаг хүмүүсийн орлого, хөрөнгийг баталгаажуулсан баримт бичиг (хэрэв өргөдөл гаргагчтай нэг өрхөд хамтран амьдардаг хүмүүс байгаа бол)
 - キ 住居の賃貸借契約書の写し（賃貸借契約を締結している場合）
Оршин суугаа байрны түрээсийн гэрээний хуулбар (хэрэв түрээсийн байртай бол)
 - ク 各種団体や個人からの金銭援助を受けていること及び援助の内容を疎明する資料（各種団体や個人からの金銭援助を受けている場合）
Төрөл бүрийн нийгэмлэгүүд болон хувь хүмүүсээс санхүүгийн тусламж авч буй гэдгээ нотлох тусламжийн дэлгэрэнгүй баримт бичиг (хэрэв та нийгэмлэгүүд болон хувь хүмүүсээс санхүүгийн тусламж авсан бол)
 - ケ 写真（写真の規格については、前記1(3)の写真の要件を参照してください。）
Цээж зураг (цээж зургийн талаар 1(3)-д заасан тавигдах шаардлагыг харна уу.)
- ④ 報酬を受ける活動の状況に関する届出
- Цалинтай үйл ажиллагааны бодит байдлын талаархи мэдэгдэл
- 報酬を受ける活動の許可を受けた者は、報酬を受ける活動の許可を受けた日又は直近の届出の日から6月を超えない範囲で、住居地等を管轄する地方出入国在留管理局、支局及び出張所に出頭し、「報酬を受ける活動の状況に関する届出書」（入管庁ホームページに掲載されているほか、窓口でも配布しています。）を提出しなければなりません。
- Цалинтай ажил хийх зөвшөөрөл авсан хүн, цалин хөлстэй үйл ажиллагаа эрхлэх зөвшөөрөл авсан өдөр эсвэл хамгийн сүүлд мэдэгдсэн өдрөөс хойш зургаан сарын дотор оршин суугаа газрынхаа харьяалалд харьяалагддаг Хилийн шалган нэвтрүүлэх газар болон салбар хэлтсүүдэд биеэр ирж "цалинтай үйл ажиллагааны нөхцөл байдлын тухай мэдэгдэл"-ийг (хилийн шалган нэвтрүүлэх газрын вэб хуудас болон биеэр ирж авах боломжтой).

(6) 仮滞在の許可の取消し

(6) Түр оршин суух зөвшөөрлийг цуцлах

仮滞在の許可を受けた者がその付された条件に違反した場合、許可なく報酬を受ける活動を行った場合、不正に難民等認定を受ける目的で偽変造された資料を提出した場合、虚偽の陳述をした場合等には仮滞在の許可が取り消されることがあります。

Түр оршин суух зөвшөөрөл авсан этгээд түүнд тавигдсан шаардлагыг зөрчсөн, зөвшөөрөлгүй цалинтай хөдөлмөр эрхэлсэн, дүрвэгчийн зөвшөөрөл авах зорилгоор хуурамчаар үйлдсэн, бичиг баримтад засвар хийж худал мэдүүлэг өгсөн бол түр оршин суух зөвшөөрлийг хүчингүй болгох болно.

3 難民認定証明書等の交付

3 Дүрвэгчийн зөвшөөрөл олгох

法務大臣が難民であると認定した外国人には、難民認定証明書が交付され、補完的保護対象者であると認定した外国人には、補完的保護対象者認定証明書が交付されます。

Хууль зүйн сайдын тушаалаар дүрвэгчээр хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын иргэнд дүрвэгчийн зөвшөөрөл, тусгай хамгаалалтад хамрагдах гадаадын иргэнд тусгай хамгаалалтын зөвшөөрөл олгоно.

難民認定申請を行った者が難民として認定されなかった場合でも、補完的保護対象者として認定された場合には、補完的保護対象者認定証明書が交付されます。

Өргөдөл гаргагчийг дүрвэгч гэж хүлээн зөвшөөрөөгүй байсан ч түүнийг тусгай хамгаалалтын арга хэмжээ авах эрхтэй гэж хүлээн зөвшөөрсөн тохиолдолд тусгай хамгаалалтын зөвшөөрөл олгоно.

難民等としての各種の保護措置を受ける際に、難民等であることの証明を求められた場合には、これらの証明書を提示してください。

Хэрэв та дүрвэгчийн хувьд янз бүрийн хамгаалалтын арга хэмжээ авахдаа дүрвэгч гэдгээ нотлохыг хүсвэл эдгээр бичиг баримтыг үзүүлнэ үү.

4 在留資格に係る許可

4 Оршин суух статусын зөвшөөрөл

難民等として認定された外国人が在留資格未取得外国人であるときは、一定の退去強制事由に該当せず、かつ、一定の刑罰法令違反により懲役等に処されたことがないときなど、一定の要件を満たした場合には、定住者の在留資格が一律に付与されます。

Дүрвэгч гэж хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын иргэн нь оршин суух зөвшөөрөл аваагүй байх тохиолдолд, албадан гаргах тодорхой үндэслэлд хамаарахгүй, эрүүгийн тодорхой хууль тогтоомж зөрчсөний улмаас хуулийн шийтгэл аваагүй байх зэрэг тодорхой шаардлага хангаж байвал, тогтмол оршин суух эрхийг адил олгоно.

これにより、3月を超える在留期間となった外国人には在留カードが交付されます。

Үүнтэй улбаалан, 3 сараас дээш хугацаагаар оршин суух гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгоно.

第4 審査請求

4-р хэсэг: Шалгуулах хүсэлт гаргах

1 審査請求手続

1 Шалгуулах хүсэлт гаргах журам

(1) 審査請求人

(1) Шалгуулах хүсэлт гаргагч

難民等認定申請をしたものの認定されなかった外国人や難民等の認定を取り消された外国人は、法務大臣に対し、審査請求をすることができます。

Дүрвэгчийн зөвшөөрөл авах хүсэлт гаргасан боловч татгалзсан хариу авсан, мөн дүрвэгчийн зөвшөөрөл нь хүчингүй болсон гадаадын иргэд Хууль зүйн сайдад шалгуулах хүсэлт гаргаж болно.

(2) 審査請求ができる期間

(2) Шалгуулах хүсэлт гаргаж болох хугацаа

審査請求期間は、難民等の認定をしない旨の通知又は難民等の認定を取り消した旨の通知を受けた日から 7 日以内となっています。ただし、天災その他やむを得ない理由があるときは、7 日経過後であっても審査請求をすることができます。

Шалгуулах хүсэлт гаргах хугацаа нь дүрвэгчийн зөвшөөрөл өгөхөөс татгалзсан хариу авсан эсвэл хүчингүй болгосон тухай мэдэгдлийг хүлээн авснаас хойш 7 хоногийн дотор байдаг. Гэвч байгалийн гамшиг болон бусад зайлшгүй шалтгаан гарсан тохиолдолд 7 хоног өнгөрсөн ч хянан шалгуулах хүсэлт гаргаж болно.

(3) 審査請求の窓口

(3) Шалгуулах хүсэлтийг хүлээж авах цонх

審査請求は、難民等認定申請の場合と同様、審査請求人の住居地等を管轄する地方出入国在留管理局、支局及び出張所で行うことができます。

Шалгуулах хүсэлтийг дүрвэгчийн зөвшөөрөлхүссэн өргөдлийн нэгэн адил хүсэлт гаргагчийн оршин суугаа газрын харьяалалтай Хилийн шалган нэвтрүүлэх газар болон салбар хэлтсүүдэд мэдүүлж болно.

なお、代理人による審査請求が認められるほか、必要書類を郵送して審査請求をすることもできます。地方出入国在留管理局・支局における審査請求窓口については、本案内の最終ページを参照してください。

Бие төлөөлөгчөөр дамжуулан шалгах хүсэлт гаргахыг зөвшөөрөх бөгөөд гадна шаардлагатай бичиг баримтыг шуудангаар илгээж хянуулах хүсэлт гаргаж болно. Орон нутгийн хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын газар болон салбар хэлтэст хэрхэн шалгах хүсэлт гаргах тухай мэдээллийг энэхүү гарын авлагын сүүлийн хуудаснаас харна уу.

(4) 審査請求に必要な書類

(4) Шалгуулах хүсэлт гаргахад шаардлагатай бичиг баримтууд

次の書類を提出してください。

Дараах бичиг баримтыг бүрдүүлнэ үү.

- | | |
|---|--------|
| ① 審査請求書（窓口に備え付けてあります。） | 1 通 |
| Шалгуулах хүсэлтийн маягт（хүлээн авах цонхноос авах боломжтой） | 1 хувь |
| ② 審査請求の理由を立証する資料（陳述書でも差し支えありません。） | 1 通 |
| Шалгуулах хүсэлт гаргах болсон шалтгааныг нотлох баримт бичиг（өргөдөл байсан ч болно） | 1 хувь |

2 難民審査参与員

2 Дүрвэгсдийг хянан шалгах комиссын гишүүн

難民審査参与員は、人格が高潔であって、審査請求に関し公正な判断をすることができ、かつ、法律又は国際情勢に関する学識経験を有する者のうちから任命されています。また、難民審査参与員を「審理員」とみなして行政不服審査法が適用され、難民審査参与員は審理を主宰し法務大臣に意見を述べることとなっています。なお、法務大臣は、審査請求の裁決に当たっては、難民審査参与員の意見を聴かなければならないこととされています。

Дүрвэгсдийг хянан шалгах комиссын гишүүнээр, ёс суртахууны өндөр чадвартай, шалгуулах хүсэлтийг нь шударгаар шийдвэрлэж чаддаг, хууль эрх зүй болон олон улсын харилцааны чиглэлээр мэдлэг болон ажлын туршлагатай хүн томилогддог. Түүнчлэн, Дүрвэгсдийн шалгалтын зөвлөхүүдийг "Шалгалтын ажилтан" гэж тооцдог бөгөөд Захиргааны хэргийн давж заалдах тухай хуулийн дагуу Дүрвэгсдийн шалгалтын зөвлөхүүд хуралдааныг даргалж, Хууль зүйн сайдад санал бодлоо илэрхийлэх үүрэгтэй. Хууль зүйн сайд шалгуулах хүсэлтийг шийдвэрлэхдээ дүрвэгсдийн шалгалтын зөвлөхүүдийн саналыг сонсох ёстой.

3 法務大臣の裁決

3 Хууль зүйн сайдын тогтоол

法務大臣が、審査請求には理由がある旨の裁決をし、難民又は補完的保護対象者と認定された外国人には、それぞれ難民認定証明書又は補完的保護対象者認定証明書が交付されます。

Хууль зүйн сайд хянан шалгуулах хүсэлтийг үндэслэлтэй гэж үзвэл дүрвэгч гэж хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын иргэн, тусгай хамгаалалтад хамрагдах иргэнд дүрвэгсдийн зөвшөөрлийн гэрчилгээ болон тусгай хамгаалалтын зөвшөөрөл бүхий гэрчилгээг тус тус олгоно.

難民等として認められた外国人が在留資格未取得外国人であるときは、一定の退去強制事由に該当せず、かつ、一定の刑罰法令違反により懲役等に処されたことがないときなど、一定の要件を満たした場合には、定住者の在留資格が付与されます。

Дүрвэгчээр хүлээн зөвшөөрөгдсөн гадаадын иргэн оршин суух зөвшөөрлийн статусгүй байх тохиолдолд, албадан гаргах үндэслэл гаргаагүй, эрүүгийн тодорхой хууль тогтоомж зөрчсөн хэргээр хорих ял шийтгүүлж байгаагүй гэх мэт тодорхой шаардлагыг хангасан бол удаан хугацаагаар оршин суух эрх олгоно.

これにより、3月を超える在留期間となった外国人には在留カードが交付されます。

Үүнд үндэслэн 3 сараас дээш хугацаагаар оршин суусан гадаадын иргэнд оршин суух зөвшөөрлийн үнэмлэх олгоно.

第5 難民旅行証明書

5-р хэсэг Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ

難民の認定を受けて在留している外国人が日本から出国しようとするときは、法務大臣から難民旅行証明書の交付を受けることができます。

Дүрвэгчээр зөвшөөрөлтэй оршин сууж буй гадаад иргэн, япон улсын хилээр гарахыг хүсвэл Хууль зүйн сайдаас дүрвэгсдийн аялалын гэрчилгээ авч болно.

1 申請窓口

1 Өргөдөл өгөх цонх

難民旅行証明書の交付申請の窓口は、難民認定申請の窓口（第3の1の(2)参照。）と同じです。申請は本人出頭が原則ですが、申請者が16歳未満の場合や病気その他の理由により自ら出頭することができない場合は、父母、配偶者、子又は親族がその者に代わって申請を行うことができます。この場合において、代理申請者は、旅券、在留カード等、出生証明書、住民票の写し等代理資格を疎明する資料を提示してください。

Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ авах хүсэлтийг дүрвэгсдийн зөвшөөрөл хүсэх өргөдөл авах цонхтой адил хэсэгт хүлээж авна (3.1.(2) хэсгийг үзнэ үү). Өргөдлийг өөрийн биеэр өгөх ёстой ч 16 нас хүрээгүй, өвчтэй болон бусад шалтгаанаар өөрийн биеэр ирэх боломжгүй бол эцэг, эх, эхнэр, нөхөр, хүүхэд, хамаатан садан нь түүний өмнөөс хүсэлт гаргаж болно. Энэ тохиолдолд итгэмжлэгдсэн төлөөлөгч нь паспорт, оршин суух зөвшөөрлийн үнэмлэх, төрсний гэрчилгээ, оршин суугчийн бүртгэлийн хуулбар зэрэг итгэмжлэгдсэн төлөөлөгчийг нотлох баримт бичгийг шалгуулах хэрэгтэй.

2 申請に必要な書類

2 Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд

(1) 提出書類

(1) Бүрдүүлэх бичиг баримтууд

ア 難民旅行証明書交付申請書（入管庁ホームページに掲載されているほか、窓口でも配布しています。） 1 通

Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ хүсэх өргөдлийн маягт（Хилийн шалган нэвтрүүлэх газрын веб хуудас болон хүлээн авах цонх дээр ирж авч болно） 1 хувь

イ 写真（提出の日前6か月以内に撮影された4.5 cm × 3.5 cmの無帽、正面上半身のもので、裏面に氏名及び生年月日が記載されているもの。） 2 葉

Цээж зураг（өргөдөл өгөхөөс 6 сарын өмнө авсан, 4,5 cm x 3,5 cm хэмжээтэй, малгайгүй, цээж зураг байх бөгөөд, ард талд нь овог нэр, төрсөн өдрөө бичсэн байх） 2 хувь

ウ 難民旅行証明書（既に交付を受けている場合）

Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ（хэрэв өмнө нь авсан тохиолдолд）

エ 難民旅行証明書の交付を受けている者が同証明書を提出できない場合にあっては、その理由を記載した書類 1 通

Дүрвэгсдийн аялалын гэрчилгээ авсан этгээд уг гэрчилгээгээ үзүүлэх боломжгүй бол учир шалтгаанаа бичсэн өргөдөл. 1 хувь

オ 旅券又は在留資格証明書を提示できない者にあつては、その理由を記載した書類 1 通
Паспорт эсвэл оршин суух эрхийн гэрчилгээгээ үзүүлэх боломжгүй бол учир шалтгаанаа бичсэн өргөдөл 1 хувь

(2) 提示書類

(2) Бүрдүүлэх бичиг баримт

ア 難民認定証明書

Дүрвэгсдийн итгэмжлэл

イ 中長期在留者にあつては、旅券（日本国政府の発行した難民旅行証明書を除く。）及び在留カード

Дунд болон урт хугацааны оршин суугчдын хувьд паспорт (Японы засгийн газраас гаргасан дүрвэгсдийн аялалын гэрчилгээ үл хамаарна) болон оршин суух зөвшөөрлийн үнэмлэх

ウ 特別永住者にあつては、旅券及び特別永住者証明書

Тусгай байнгын оршин суугчдын хувьд гадаад паспорт болон тусгай байнгын оршин суугчийн гэрчилгээ

エ 中長期在留者及び特別永住者以外の者にあつては、旅券又は在留資格証明書

Дунд болон удаан хугацаагаар оршин суугч болон тусгай байнгын оршин суугчаас бусад хүмүүсийн хувьд гадаад паспорт эсвэл оршин суух зөвшөөрлийн гэрчилгээ

(注) 代理申請の場合であっても、申請者本人の在留カードや旅券などの提示が必要になります。代理人が在留カードや旅券などを預かっている間、代理人はこれらの写しを作成し、適宜、代理人の氏名及び代理人による手続中である旨を記載の上、申請者にこれらの写しを携帯させるようにしてください。

(Анхааруулга) Төлөөлөгчөөр өргөдөл мэдүүлэх тохиолдолд ч, өргөдөл гаргагчийн оршин суух зөвшөөрлийн үнэмлэх болон паспорт зэргийг шалгуулах хэрэгтэй. Төлөөлөгч нь оршин суух зөвшөөрлийн үнэмлэх, гадаад паспорт гэх мэт баримт бичгүүдийг түр авсан байх хугацаанд, эдгээр бичиг баримтуудын хуулбарыг үйлдэж, итгэмжлэгдсэн төлөөлөгчийн нэр, төлөөлөн бичиг баримт бүрдүүлэлт хийж байгааг бичиж, уг хуулбарыг өргөдөл гаргарч байнга биедээ авч явах ёстой.

3 難民旅行証明書の有効期間

3 Дүрвэгсдийн аялалын гэрчилгээний хүчинтэй хугацаа

難民旅行証明書の有効期間は、難民旅行証明書の発行の日から 5 年です。有効期間中は、原則として何度でも日本から出国し、日本に再入国することができます。ただし、日本での在留期間の残りが 5 年未満の場合等で、難民旅行証明書の有効期間とは別に「日本に入国できる期限」が定められているときは、その期限までに日本に再入国しなければなりません。日本に再入国できる期限は、難民旅行証明書の 3 ページに記載されていますので、必ずこれを確認し、難民旅行証明書の有効期間と混同することのないように注意してください。

Дүрвэгсдийн аялалын гэрчилгээний хүчинтэй хугацаа нь паспорт олгосон өдрөөс хойш 5 жилийн

хугацаанд хүчинтэй байна. Зарчмын хувьд паспортын хүчинтэй хугацаанд Японоос хэдэн ч удаа гарч, дахин орж болно. Гэхдээ япон улсад оршин суух зөвшөөрлийн хугацаа 5 жилээс бага хугацаа үлдсэн тохиолдолд дүрвэгсдийн аялалын гэрчилгээний хүчинтэй хугацаанаас тусад нь "Япон руу нэвтрэх эцсийн хугацаа" тогтоогдсон байвал, тухайн хугацаанд багтан японд ирэх ёстой. Японд дахин нэвтрэх эцсийн хугацааг дүрвэгсдийн аялалын гэрчилгээний 3-р хуудсанд бичсэн байгаа тул үүнийг сайтар шалгаж, дүрвэгсдийн аялалын гэрчилгээний хугацаатай андуурч болохгүй.

4 手数料

4 Хураамж

難民旅行証明書の交付を受ける際には、所要の額を納付しなければなりません。また、外国で難民旅行証明書の有効期間の延長手続を行う場合にも、所要の手数料をその国の通貨で納付しなければなりません。

Дүрвэгсдийн аялалын гэрчилгээг хүлээн авахдаа шаардлагатай хураамжийг төлөх ёстой. Мөн гадаад улсад дүрвэгсдийн аялалын гэрчилгээний хугацааг сунгах хүсэлт гаргахдаа ч тухайн улсын мөнгөн тэмдэгтээр шаардагдах хураамжийг төлөх ёстой.

第6 一時庇護のための上陸許可

6-р хэсэг Түр оргонох зорилгоор хил нэвтрэх зөвшөөрөл олгох

一時庇護のための上陸許可は、船舶等に乗っている外国人が難民条約に規定する理由その他これに準ずる理由により、難民に該当する可能性がある場合、又は船舶等に乗っている外国人が補完的保護対象者に該当する可能性がある場合であって、その外国人を一時的に上陸させることが相当であると思料するときに、入国審査官が許可するもので、これは、「国が取り急ぎ保護する（領土的庇護）」ための緊急措置として与えられるものです。

Хөлөг онгоцонд суугаа гадаадын иргэнийг Дүрвэгсдийн тухай конвенцид заасан шалтгаанаар болон бусад үүнтэй төстэй шалтгаанаар дүрвэгч гэж үзэх магадлалтай тохиолдолд, эсвэл хөлөг онгоцонд сууж явсан гадаадын иргэнийг тусгай хамгаалалтад хамрагдах гэж үзэх магадлалтай тохиолдолд, тэрхүү гадаадын иргэнд түр орогнох зөвшөөрөл олгохыг зөвшөөрсөн тохиолдолд түр орогнох буух зөвшөөрлийг цагаачлалын албаны байцаагч олгоно. Үүнийг тус улсад "нэн даруй хамгаалалт (нутаг дэвсгэрийн орогнол)" үзүүлэх яаралтай арга хэмжээ болгон олгогддог.

1 申請

1 Өргөдөл гаргах

(1) 対象者

(1) Зорилтот иргэн

船舶又は航空機に乗っている外国人

Усан онгоц эсвэл нисэх онгоцонд суугаа гадаадын иргэн

(2) 申請方法

(2) Өргөдөл гаргах арга

到着した空海港に所在する出入国在留管理官署において、申請者本人が自ら申請してください。ただし、申請者が 16 歳未満である場合や病気その他の理由により自ら申請できない場合は、申請者に同行する父母、配偶者、子又は親族その他の同行者等が代わって申請を行うことができます。

Өргөдөл гаргагч нь агаарын болон усан боомт дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын албанд биечлэн өргөдөл гаргах ёстой. Харин өргөдөл гаргагч нь 16 нас хүрээгүй эсвэл өвчний болон бусад шалтгааны улмаас өөрөө виз мэдүүлэх боломжгүй бол эцэг эх, эхнэр/нөхөр, хүүхэд, хамаатан садан болон бусад дагалдан яваа хүн төлөөлөн хүсэлт гаргаж болно.

2 申請に必要な書類

2 Өргөдөл гаргахад шаардлагатай бичиг баримтууд

(1) 提出書類

(1) Бүрдүүлэх бичиг баримтууд

ア 外国人入国記録（通常 E/D カードと呼ばれています。航空機内で配布される場合もありますが、空港の場合であれば、航空会社のカウンターや入国審査ブースで入手することがで


- きます。) 1 通
- Гадаад иргэний хилээр нэвтрэх бүртгэл (ихэвчлэн E/D карт гэж нэрлэдэг. Үүнийг онгоцонд тараадаг ч нисэх онгоцны буудалд байгаа тохиолдолд агаарын тээврийн компанийн хүлээн авах хэсэг болон хилийн шалганы хэсгээс авч болно. 1 хувь
- イ 申告書（身分事項や申請の理由等を記載するもので、空海港に所在する出入国在留管理官署で配布しています。） 1 通
- Мэдэгдэл (таны хувийн мэдээлэл болон өргөдөл гаргасан шалтгааныг тайлбарлах бичиг бөгөөд нисэх онгоцны буудал, далайн боомт дахь хилийн шалган нэвтрүүлэх албанаас авах боломжтой.) 1 хувь
- ウ 写真（所持している場合） 2 葉
- Цээж зураг (хэрэв танд байгаа бол) 2 хувь
- エ 庇護を求める理由があることを証明する資料（所持している場合） 1 通
- Орогнол хүсэх үндэслэлтэй болохыг нотлох баримт бичиг (хэрэв танд байгаа бол) 1 хувь
- (2) 提示書類
- (2) Шалгуулах бичиг баримт
- ア 旅券等の渡航文書（所持している場合）
- Гадаад паспорт эсвэл бусад аялалын бичиг баримт (хэрэв танд байгаа бол)
- イ 身分を証明する文書（所持している場合）
- Биеийн байцаалт болох бичиг баримт (хэрэв танд байгаа бол)
- 3 一時庇護許可書の交付
- 3 Түр орогнох зөвшөөрөл олгох

審査の結果、一時庇護のための上陸が許可された場合は、一時庇護許可書が交付されます。同許可書には、上陸期間、住居及び行動範囲等の上陸のための条件が記載されます。

Хяналт шалгалтын үр дүнд түр хоргодох зорилгоор хилээр нэвтрэхийг зөвшөөрсөн тохиолдолд түр орогнох зөвшөөрөл олгоно. Зөвшөөрөлд оршин суух хугацаа, байрлах газар, үйл ажиллагааны цар хүрээ зэрэг нөхцөлийг тусгана.

付録 難民認定手続・補完的保護対象者認定手続図解

Хавсралт: Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх, тусгай хамгаалалтад хамрагдах журмын бүдүүвч зураг





(難民認定申請及び補完的保護対象者認定申請の窓口)

(Дүрвэгчийн зөвшөөрөл хүсэх, тусгай хамгаалалтад хамрагдах өргөдөл хүлээж авах цонх)

札幌出入国在留管理局 Саппоро дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査部門 Шалганы хэлтэс
仙台出入国在留管理局 Сэндаи дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査第一部門 Шалганы 1-р хэлтэс
東京出入国在留管理局 Токио дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	難民調査第一部門 Дүрвэгсдийг байцаах 1-р хэлтэс
成田空港支局 Нарита онгоцны буудал дахь салбар хэлтэс	審査管理部門 Хянан шалгах хэлтэс
羽田空港支局 Ханэда онгоцны буудал дахь салбар хэлтэс	審査管理部門 Хянан шалгах хэлтэс
横浜支局 Ёкохама дахь салбар хэлтэс	就労・永住審査部門 Хөдөлмөр эрхлэлт болон байнгын оршин суух шалгалтын хэлтэс
名古屋出入国在留管理局 Нагояа дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	難民調査部門 Дүрвэгсдийг байцаах хэлтэс
中部空港支局 Чюбү онгоцны буудал дахь салбар хэлтэс	審査管理部門 Хянан шалгах хэлтэс
大阪出入国在留管理局 Осака дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	永住審査部門 Байнгын оршин суух шалганы хэлтэс
関西空港支局 Кансаи онгоцны буудал дахь салбар хэлтэс	審査管理部門 Хянан шалгах хэлтэс
神戸支局 Кобэ дахь салбар хэлтэс	審査部門 Шалганы хэлтэс
広島出入国在留管理局 Хирошима дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	就労・永住審査部門 Хөдөлмөр эрхлэлт болон байнгын оршин суух шалгалтын хэлтэс
高松出入国在留管理局 Такамацү дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査部門 Шалганы хэлтэс
福岡出入国在留管理局 Фүкүока дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査管理部門 Хянан шалгах хэлтэс
那覇支局 Хана дахь салбар хэлтэс	審査部門 Шалганы хэлтэс

(審査請求の窓口)

(Шалгуулах хүсэлт хүлээж авах цонх)

札幌出入国在留管理局 Саппоро дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査部門 Шалганы хэлтэс
仙台出入国在留管理局 Сэндаи дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査第二部門 Шалганы 2-р хэлтэс
東京出入国在留管理局 Токио дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	難民審判部門 Дүрвэгсдийн асуудлыг шүүх хэлтэс
成田空港支局 Нарита онгоцны буудал дахь салбар хэлтэс	第二審判部門 2-р Хяналтын хэлтэс
羽田空港支局 Ханэда онгоцны буудал дахь салбар хэлтэс	審判部門 Шүүх хэлтэс
横浜支局 Ёкохама дахь салбар хэлтэс	審判部門 Шүүх хэлтэс
名古屋出入国在留管理局 Нагояа дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	難民審判部門 Дүрвэгсдийн асуудлыг шүүх хэлтэс
中部空港支局 Чюбү онгоцны буудал дахь салбар хэлтэс	審査管理部門 Хянан шалгах хэлтэс
大阪出入国在留管理局 Осака дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審判部門 Шүүх хэлтэс
関西空港支局 Кансаи онгоцны буудал дахь салбар хэлтэс	審判部門 Шүүх хэлтэс
神戸支局 Кобэ дахь салбар хэлтэс	審査部門 Шалганы хэлтэс
広島出入国在留管理局 Хирошима дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審判部門 Шүүх хэлтэс
高松出入国在留管理局 Такамацү дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審査部門 Шалганы хэлтэс
福岡出入国在留管理局 Фүкүока дахь Хилийн шалган нэвтрүүлэх, оршин суух хяналтын алба	審判部門 Шүүх хэлтэс
那覇支局 Хана дахь салбар хэлтэс	審査部門 Шалганы хэлтэс